



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Г “Бэрэн майнинг” ХХК-ийн нийтэд санал Ү
болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 17, 42 дугаар зүйл, “Бэрэн майнинг” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2011 оны 41/11 дугаар тогтоол, 2012 оны 02/12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ НЬ:**

1. “Бэрэн майнинг” ХХК-ийн нэг бүр нь 157.35 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий гаргасан болон тус компанийн өмчлөл дэх нийт 1 740 813 320 /нэг тэрбум долоон зуун дөчин сая найман зуун арван гурван мянга гурван зуун хорь/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар/Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан нийт 1 740 813 320 ширхэг “Бэрэн майнинг” ХХК-ийн энгийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг дор дурдсан хуваарийн дагуу хөрвүүлэн бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/Т.Гандулам/-д үүрэг болгосугай:

Өмчлөгчийн нэр	Өмчлөлд хөрвүүлэн бүртгэх хувьцааны тоо	Нийт энгийн хувьцаанд эзлэх хувь хэмжээ
“Бэрэн майнинг” ХК	522 243 996	30 %
“Бэрэн групп” ХХК	621 470 355	35.70 %
“Сор метал” ХХК	597 098 969	34.30 %

3. Энэ тогтоолын 2-т заасан хүснэгтэд “Бэрэн майнинг” ХХК-ийн өмчлөлд хөрвүүлэн бүртгэсэн нэг бүр нь 157.35 төгрөгийн нийт 522 243 996 /таван зуун хорин хоёр сая хоёр зуун дөчин гурван мянга есөн зуун ерэн зургаа/ ширхэг гаргасан боловч бусдад

худалдаагүй хувьцааг “тогтоосон үнийн аргаар” тус бүрийг нь 250 /хоёр зуун тавь/ төгрөгөөр тогтоон нийтэд анх удаа санал болгон худалдахыг зөвшөөрсүгэй.

4. “Бэрэн майнинг” ХХК-ийн 2012 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02/12 тоот хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу энэ тогтоолын 3-т заасан хувьцааг нийтэд санал болгон худалдахад “Бэрэн групп” ХХК болон “Сор метал” ХХК-д хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэхгүй болохыг тэмдэглэсүгэй.

5. Энэхүү тогтоолын 3-т заасан нийтэд санал болгон гаргах энгийн хувьцааны “Бэрэн майнинг” ХК-ийн 30 хувийг үнэт цаасыг нийтэд санал болгон сурталчилж эхэлсэн өдрөөс хойш ажлын 10-аас доошгүй хоногийн дараа худалдан авах захиалгыг авч эхлэх бөгөөд үргэлжлэх хугацаа нэг сараас илүүгүй байна.

6. Энэхүү тогтоолын 5-д заасан захиалга, сурталчилгаа явуулсан тайлан зэрэг холбогдох бичиг баримтын дагуу Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хувьцааны арилжаа, төлбөр тооцоо, бүртгэлийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

7. Нийт гаргах энгийн хувьцааны 30 хувийн 60 хувь буюу 313 346 398 ширхэгээс доошгүй арилжигдсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

8. Энэнхүү тогтоолын 7-д заасны дагуу Хорооноос үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж дүгнэх хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг “ҮЦТТТХТ” ХХК-д байрших тусгай дансанд тусгаарлахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасыг нээлттэй хүрээнд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон гэж Хороо үзсэн тохиолдолд үнэт цаас худалдсаны орлого буюу үнэт цаас гаргагч “Бэрэн майнинг” ХХК-ийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь дансанд байршсан мөнгөн хөрөнгийг тус компани хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг шинэчилсэн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг захиран зарцуулах болон удирдлагын бүтцэд өөрчлөлт орох талаар холбогдох шийдвэрийг гаргаж тус Хороонд ирүүлэх хүртэл хугацаанд тусгаарлахаар тогтсугай.

10. Энэхүү тогтоолын 2-т заасан нэр бүхий хувь нийлүүлэгчдийн хувьцааг өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэсэн өдрөөс эхлэн “Тамирын гол цогцолбор” төсөл бүрэн хэрэгжиж, эдийн засгийн үр өгөөжөө өгч эхлэх хүртэлх хугацаанд тусгаарлах, Хорооны хуралдаанаар “Бэрэн майнинг” ХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн энэхүү төслийн

хэрэгжилт, эдийн засгийн үр ашгийн тооцоог хэлэлцэн, Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр тусгаарлалтаас чөлөөлөхөөр тогтсугай.

11. “Бэрэн майнинг” ХХК-иас нийтэд санал болгон гаргаж буй хувьцаанаас стратегийн хөрөнгө оруулагч хэлбэрээр худалдан авч байгаа тохиолдолд уг этгээдийн худалдан авсан бүх хувьцааг үнэт цаасны анхдагч зах зээл эхэлсэн өдрөөс эхлэн “Тамирын гол цогцолбор” төсөл бүрэн хэрэгжиж, эдийн засгийн үр өгөөжөө өгч эхлэх хүртэлх хугацаанд тусгаарлах болохыг олон нийтэд мэдэгдэж ажиллахыг “Бэрэн майнинг” ХХК/Б.Мөнхдалай/, “Би Ди Сек” ХК/Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

12. Энэхүү тогтоолын 11-т заасны дагуу стратегийн хөрөнгө оруулагч хэлбэрээр хувьцаа худалдан авах этгээд байгаа бол уг этгээдүүдийн талаар үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө Хороонд мэдэгдэж, холбогдох шийдвэрийг гаргуулах шаардлагатай болохыг “Бэрэн майнинг” ХХК/Б.Мөнхдалай/, “Би Ди Сек” ХК/Д.Даянбилгүүн/-д анхааруулсугай.

13. “Бэрэн майнинг” ХХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/-д үүрэг болгосугай.

14. Энэхүү тогтоолын 8, 9, 10, 11-т заасан үнэт цаас, мөнгөн хөрөнгийг тусгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Хорооны хуралдааны шийдвэрээр тусгаарлалтаас чөлөөлөхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

15. “Бэрэн майнинг” ХХК-ийн нийтэд санал болгон худалдсан үнэт цаасыг худалдан авсан хувьцаа эзэмшигчдийн тус компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох эрхийг хангах зорилгоор Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.5 дахь заалт нь тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зохион байгуулахад үйлчлэхгүй болохыг тогтоож, хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах “бүртгэлийн өдөр”-ийг хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах өдрийн өмнөх өдөр байхаар тогтоосугай.

16. Тус компанийн шинээр үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Бэрэн майнинг” ХХК/Б.Мөнхдалай/, “Би Ди Сек” ХК/Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

1/ энэхүү тогтоолын 3-т заасан нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 157.35 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 522 243 996 /таван зуун хорин хоёр сая хоёр зуун дөчин гурван мянга есөн зуун ерэн зургаа/ ширхэг хувьцаа гаргах тухай үнэт цаасны товч ба дэлгэрэнгүй танилцуулгыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт

цаасны танилцуулгад үндэслэн холбогдох журмын дагуу үнэт цаасыг нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж дууссанаас хойш холбогдох журмын дагуу 10 хоногийн дотор үнэт цаасны гүйлгээний талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд ирүүлэх;

3/ үнэт цаасны танилцуулгад заасны дагуу үнэт цаасыг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулж, арилжаалагдаагүй үлдсэн хувьцааны талаар холбогдох шийдвэр гаргуулахаар Хороонд хандаж шийдвэрлүүлэх;

4/ үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Бэрэн майнинг” ХХК/Б.Мөнхдалай/-д үүрэг болгосугай.

17. Үнэт цаас гаргагч, түүний хувь нийлүүлэгчид болох “Бэрэн групп” ХХК, “Сор металл” ХХК болон Компанийн тухай хуулийн 6.13-т заасны дагуу эдгээр компанийн нэгдэлд хамаарах компаниуд, мөн хуулийн 6.14-т заасны дагуу эдгээр компанийн зэргэлдээ компаниуд “Бэрэн майнинг” ХХК-ийн нийтэд санал гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авах захиалга өгөх болон хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсний дараа нэг жилийн хугацаанд худалдан авахыг хориглосугай.

18. “Бэрэн майнинг” ХХК нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болж буйгаа Улсын бүртгэлийн албанд энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш 10 хоногийн дотор бүртгүүлж, Хороонд мэдэгдэхийг “Бэрэн майнинг” ХХК/Б.Мөнхдалай/-д даалгасугай.

19. “Монголын компанийн засаглалын кодекс”-т нийцүүлэн ажиллахыг “Бэрэн майнинг” ХХК/Б.Мөнхдалай/-д даалгасугай.

20. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН